

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД,
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2021 оны дугаар
сарын-ны өдөр

Дугаар/...../...../

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журам”-ыг шинэчлэн баталсугай.

2. “Хамтарсан багаас үзүүлэх үйлчилгээний жишиг зардлыг тооцох аргачлал”-ыг хамтарсан тушаалын нэгдүгээр, “Хамтарсан багаас үзүүлэх үйлчилгээний маягт”-ыг хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Энэхүү журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, салбар зөвлөл, Цагдаагийн газар /хэлтэс/, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, аймаг, нийслэл, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /хэлтэс/, Эрүүл мэндийн газар, аймаг, нийслэл, дүүргийн Эрүүл мэндийн төвүүдэд тус тус үүрэг болгосугай.

4. Хамтарсан багийн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг жил бүр эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөв, холбогдох салбарын төсөвт тусгаж, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрт хамруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Н.Баярмаа/-т, Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Э.Энхтуяа/-т, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба /Л.Нямгэрэл/-д, Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Л.Энхсайхан/ -т тус тус даалгасугай.

6. Энэ журам гарсантай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/173, А/259, А/380 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ГАРЫН ҮСЭГ

ХАМТАРСАН БАГИЙН АЖИЛЛАХ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь сум, /аймгийн төвийн сумын баг/, нийслэлийн хорооны түвшинд “Хамтарсан баг”-ийн үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, гишүүдийн гүйцэтгэх чиг үүрэг, санхүүжилт, үйл ажиллагаанд тавих хяналт, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай болон бусад холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хамтарсан баг нь Гэр бүлийн хүчирхийлэлттэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасан үйлчилгээг анхан шатанд үзүүлнэ.

1.3. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, гэр бүлд хамгааллын үйлчилгээ, хүчирхийллийн хохирогчид түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлж байгаа төр, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, иргэн нь Хамтарсан багт шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, харилцан уялдаатай хамтран ажиллана.

1.4. Хамтарсан баг нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан үйлчилгээг хүчирхийллийн хохирогчид холбогдох журмын дагуу үзүүлэх бөгөөд шаардагдах зардлыг улс, орон нутгийн төсөв болон салбар тус бүрийн төсвөөс санхүүжүүлнэ.

1.5. Хамтарсан баг нь нийгмийн бүхий л орчинд хүүхэд, гэр бүлийн эсрэг хүчирхийлэл, гэмт хэрэг, зөрчил, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах, хүчирхийллийг таслан зогсоох, аюулгүй байдлыг хангах, нөхцөл байдлын үнэлгээ хийх, хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүнийг мэргэжлийн сургалтад хамруулах, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эмнэлгийн байгууллагын шаардлагатай үйлчилгээ үзүүлэх, гэр бүлд нь дэмжлэг үзүүлэх замаар нөхөн сэргээх, шаардагдах бусад үйлчилгээнд холбон зуучилж, үйлчилгээний үр дүнг хянана.

Хоёр. Хамтарсан багийн удирдлага, зохион байгуулалт, дэмжлэг

2.1. Хамтарсан багийн удирдлага, зохион байгуулалт:

2.1.1. Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн орон нутагт ажиллах Хамтарсан багийг сум/баг, хорооны, сургуулийн, хүүхэд, гэр бүлийн, халамжийн нийгмийн ажилтан, өрхийн эмч, цагдаагийн алба хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөллийн бүрэлдэхүүнтэй байгуулна.

2.1.2. Хамтарсан багийн бүрэлдэхүүнд шаардлагатай тохиолдолд өрхийн эмнэлгийн дарга эсхүл эрүүл мэндийн нийгмийн ажилтан, цэцэрлэгийн арга зүйчийг оролцуулж болно.

2.1.3. Хамтарсан багийг сум, хороо/баг/-ийн Засаг дарга /цаашид “багийн ахлагч” гэх/ ахалж, багаа тогтвортой ажиллах нөхцөл бүрдүүлэх, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах үүргийг хүлээнэ.

2.1.4. Хамтарсан багийн нарийн бичгийн даргаар суманд Засаг даргын Тамгын газрын нийгмийн бодлогын мэргэжилтэн, хороонд хөгжлийн нийгмийн ажилтан, багт багийн нийгмийн ажилтан /цаашид “нарийн бичгийн дарга” гэнэ/ ажиллана.

2.1.5. Нарийн бичгийн дарга Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасан үүргийг хүлээхээс гадна багийн гишүүдийн чиг үүргийг хуваарилах, оролцоо, үр дүнг хянах үүрэг хүлээж, багийн ажлын үр дүнгийн тайланг **Нийгмийн ажилтны мэдээллийн системд** заагдсан хугацаанд оруулна.

2.1.6. Хамтарсан баг нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20.2.2-т заасан хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийн талаарх мэдээлэл, хохирогчид үзүүлсэн үйлчилгээний талаарх статистик мэдээллийг харъяа нутаг дэвсгэр хариуцсан Цагдаагийн байгууллагад сар бүр бичгээр өгнө.

2.1.7. Хамтарсан багийн гишүүд мэргэжлийн ёс зүйг баримтлан, ажил үүргээ хариуцлагатай гүйцэтгэж, хамтарсан багийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна.

2.1.8. Хамтарсан багийн хурал төлөвлөсөн болон яаралтай хэлбэртэй байна. Төлөвлөсөн хурал нь тогтсон цаг хугацаанд, яаралтай хурал нь нөхцөл байдлыг үндэслэн багийн ахлагч эсхүл нарийн бичгийн даргын зарласнаар явагдана. Ажлын бус цагт зарласан хурал, уулзалтыг багийн ахлагчид заавал танилцуулж, зөвшилцөх, өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

2.1.9. Багийн хурал 51-ээс дээш хувийн ирцтэй тохиолдолд хүчин төгөлдөр болох ба шийдвэр нь хуралд оролцсон гишүүд хурлын тэмдэглэлд гарын үсэг зурснаар баталгаажна. Хурлын тэмдэглэлд тухайн холбогдох баримт бичгийн хувийг хавсаргаж болно.

2.1.10. Хамтарсан баг нь хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг улирал, хагас, бүтэн жилээр төлөвлөх ба үр дүнгийн тайлан, **Нийгмийн ажилтны мэдээллийн санд бүртгүүлж**, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, орон нутгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

2.1.11. Хамтарсан багийн гишүүдэд сарын нэмэлт урамшуулал олгох эсэх асуудлыг хамтарсан багийн нарийн бичгийн дарга, багийн ахлагчтай зөвшилцөж, ажлын гүйцэтгэлийн үр дүнгийн үзүүлэлтийг үндэслэн олгоно.

2.1.12. Хамтарсан багийн гишүүдийн урамшууллын хэмжээг тооцохдоо Хүүхэд хамгааллын жишиг зардлыг үндэслэнэ.

2.1.13. Энэхүү урамшууллыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-т заасны дагуу аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга тухайн жилийн төсөвт тусгах саналаа, Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд танилцуулах ба аймаг, нийслэл, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурал нь тухайн жилийн төсөвт тусган, багтаан олгоно.

2.2. Хамтарсан багт үзүүлэх дэмжлэг:

2.2.1. Аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэс нь хамтарсан багийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, идэвхжүүлэх, салбар дундын зохицуулалтыг хангах, дэмжлэг үзүүлж ажиллах ба үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж, дээд шатны удирдлагад /Засаг дарга/ танилцуулна.

2.2.2. Засаг дарга хамтарсан багийн удирдлага зохион байгуулалтыг сайжруулах, үйл ажиллагаанд санхүүгийн болон шаардлагатай бусад дэмжлэг үзүүлэх талаар шийдвэр гаргана.

2.2.3. Хамтарсан багийн үйл ажиллагаанд сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, орон нутгийн Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, эрүүл мэнд, боловсрол, халамж, цагдаагийн байгууллагын асуудал хариуцсан мэргэжилтнүүд болон бусад төрийн захиргааны байгууллагууд, гэр бүл, хүн амын бүлэг, хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр мэргэшсэн судлаач нараас бүрдсэн мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх чиглэлээр мэргэжил, арга зүйн дэмжих баг байгуулж, хамтарч ажиллана.

НЭГТГЭСЭН

2.2.4. Аймаг, дүүрэг, нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хамтарсан багт дэмжлэг үзүүлэх зорилгоор гэр бүл, хүн амын бүлэг, хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр мэргэшсэн судлаач, зөвлөх бүхий мэргэжил, арга зүйн дэмжих баг ажиллуулж болно.

2.2.5. Хамтарсан баг дараагийн шатны үйлчилгээг магадлан итгэмжлэгдсэн байгууллага, иргэнээр үзүүлж болох бөгөөд үйлчилгээний зардлыг хүүхэд хамгааллын жишиг зардлын дагуу тооцож, ажиллана.

2.2.6. Хамтарсан баг нь шаардлагатай тохиолдолд хэсгийн ахлагч, олон нийтийн цагдаа иргэний бүртгэлийн ажилтан, мэргэжлийн сэтгэл зүйч, хэлмэрч, орчуулагч, болон хүний эрх, хүүхдийн эрх, хамгаалал, хүчирхийллийн асуудлаар мэргэшсэн магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага, мэргэжилтний дэмжлэг, туслалцааг авч болно.

Гурав. Хамтарсан багийн гишүүдийн чиг үүрэг

3.1. Хамтарсан багийн ахлагч:

3.1.1. Хамтарсан багт хандсан дуудлага, мэдээллийг холбогдох маягтын дагуу хүлээн авч, бүртгэлд авна.

3.1.2. Хүчирхийллийн эрсдэлтэй мэдээлэл хүлээн авсан сум, баг, хорооны Засаг дарга Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 24.1-д заасны дагуу таслан зогсоох ажиллагааг шуурхай авч, холбогдох журмын дагуу насанд хүрсэн хохирогчийн аюулгүй байдлыг, хүүхдийг тусгай хамгаалалтаар тус тус хангаж ажиллана.

3.1.3. Хохирогчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 33.1.1, 34 дүгээр зүйлд заасан аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэгжүүлэх, шаардлагатай хохирогчийн иргэний бүртгэлийн бичиг баримтын зөрчлийг арилгуулна.

3.1.4. Үйлчлүүлэгчийн хүсэлтээр хамтарсан багаас үзүүлэх үйлчилгээг зогсоох, үйлчилгээний үр дүнг үнэлэх, хувийн хэргийг хаахдаа холбогдох баримтыг хавсарган, хянаж, гарын үсэг зурж, баталгаажуулна.

3.1.5. Хамтарсан багийн гишүүдэд олгох урамшуулал, шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх талаар дараагийн шатны байгууллагад уламжилж, шийдвэрлүүлнэ.

3.2. Нарийн бичгийн дарга:

3.2.1. Хамтарсан багт хандсан дуудлага, мэдээллийг цагдаагийн алба хаагч болон багийн ахлагчийн эзгүй байх хугацаанд нийгмийн ажилтан хүлээн авч, холбогдох маягтын дагуу бүртгэл хөтлөн, энэ тухай цагдаагийн байгууллага, хамтарсан багийн ахлагчид мэдээлнэ.

3.2.2. Гэр бүлийн хүчирхийлэл, нийгмийн бусад орчинд хүүхдийн эсрэг хүчирхийлэл гарахад хүргэж болох эрсдэл, тохиолдлыг эрт илрүүлэх зорилгоор иргэд, олон нийтэд, байгууллага, аж ахуйн нэгжид хүчирхийллийг үл тэвчих хандлага, мэдлэгийг нэмэгдүүлэх кампанит ажлыг харъяалах нутаг дэвсгэрийн судалгаа, нөхцөл байдалд үндэслэн хэрэгжүүлнэ.

3.2.3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.2, 32 дугаар зүйл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А120, А178 дугаар хамтарсан тушаалын дагуу нөхцөл байдлын үнэлгээ хийж, маягтыг бөглөнө.

3.2.4. Аюулын зэргийн болон нөхцөл байдлын үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гарсан тохиолдолд аймаг, дүүрэг эсхүл нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн байгууллагын дэмжлэг, туслалцааг авч, хамтран ажиллана.

3.2.5. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу хохирогчид сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө өгөх, шаардлагатай гэж үзвэл хамтарсан багийн хурлын шийдвэрээр уг хуулийн 38.1.1, 39.3-т заасан үйлчилгээнд холбон зуучилж, эргэх холбоотой ажиллана.

3.2.6. Хохирогчийн амь нас, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө, аюулын зэргийн үнэлгээ өндөр гарсан тохиолдолд хүчирхийлэгчийг хяналтад авах, тусгаарлах, эсхүл хохирогчийг түр хамгаалах байранд, хүүхдийг асрамжийн газар, садан төрлийн асрамж, хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд шилжүүлнэ.

3.2.7. Нарийн бичгийн дарга Хамтарсан багт ирсэн кейсийг нийгмийн ажилтны мэдээллийн санд /НАМС/ бүртгэлжүүлнэ.

3.2.8. Хүчирхийллийн хохирогчид түр хамгаалах байранд үзүүлсэн үйлчилгээний мэдээллийг хамгаалах байрны нийгмийн ажилтан гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлсэн үйлчилгээний мэдээллийн санд /etsulamj.mn/ бүртгэлжүүлсэн байна.

3.2.9. Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн хохирогчид орчуулагч, дохионы хэлмэрч, итгэмжлэгдсэн төлөөлөгч ажиллуулах шаардлагатай бол нийгмийн ажилтан хамтарсан багийн хурлаар хэлэлцүүлэн

шийдвэрлэж, аймаг, дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн байгууллагатай хамтран ажиллана.

3.2.10. Хүчирхийлэл үйлдэгчийг зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтад хамруулж, сургалтыг зохион байгуулахад аймаг, дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн байгууллага нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 44.2-т зааснаар магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж ажиллаж болно.

3.2.11. Хүчирхийллийн байнгын харилцаатай гэр бүлд үзүүлэх нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээг үйлчлүүлэгчийн хүсэлтээр үргэлжлүүлж болно.

3.2.12. Хамтарсан багийн гишүүд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомжид заасан тус тусын чиг үүргийн дагуу хамтарч ажиллана.

3.2.13. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг энэ хуульд заасны дагуу хамгаалалтад байх хугацаанд Хамтарсан багийн гишүүд болон Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байрны мэргэжилтэн нь түүний ажлын байрыг хадгалах, хөдөлмөрийн хөлсийг нөхөн тооцуулах, арга хэмжээг ажил олгогчид мэдэгдэж, үйлчилгээний нууцлалыг хадгалах үүргийг тухайн байгууллагын Үйлдвэрчний эвлэл эсхүл хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй хамтран хүлээнэ.

3.2.14. Нарийн бичгийн дарга сар бүр өөрийн хяналтын хуудсаар хамтарсан багийн үйл ажиллагааг хянаж үнэлэн багийн ахлагч болон гишүүдэд танилцуулж, шаардлагатай зөвлөмж, анхааруулгыг багийн гишүүдэд өгнө.

3.2.15. Хамтарсан багийн гишүүдэд урамшуулал олгох, үйл ажиллагааг санхүүжүүлэхэд Хүүхэд хамгааллын үйлчилгээний норматив, санхүүжүүлэх журмыг жишиг болгоно.

3.3. Өрх, сумын эмч болон эмнэлгийн мэргэжилтэн:

3.3.1. Хамтарсан багт хандсан дуудлага, мэдээллийг цагдаагийн алба хаагч болон багийн ахлагчийн эзгүй байх хугацаанд нийгмийн ажилтан, түүний эзгүйд чиг үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа багийн гишүүн холбогдох маягтын дагуу хүлээн авч, бүртгэлд авна.

3.3.2. Хохирогчийн эрүүл мэндийн байдлыг тогтоож, мэргэжлийн дүгнэлт гаргана.

3.3.3. Хохирогчийг хүлээн авч, үйлчилгээг төлөвлөх, үзүүлэх, үнэлэх, холбон зуучлах, үйлчилгээ дуусгавар болох хүртэлх бүхий л үе шатанд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлнэ.

3.3.4. Нийгмийн ажилтантай хамтран эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

3.3.5. Гэр бүлийн хүчирхийлэл, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулна.

3.3.6. Хохирогчид гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 27, 37 дугаар зүйл, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээг болон шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн дараагийн шатанд холбож, хяналттай ажиллана.

3.3.7. Хохирогчийн осол, гэмтэл, өвчлөлийн шалтгааныг тэмдэглэн баримтжуулж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний явц, үр дүнгийн талаарх мэдээллийг Хамтарсан багийн нийгмийн ажилтанд өгөх ба нийгмийн ажилтан холбогдох байгууллагын мэдээллийн санд оруулна.

3.4. Сургуулийн нийгмийн ажилтан:

3.4.1. Хамтарсан багт хандсан дуудлага, мэдээллийг цагдаагийн алба хаагч болон багийн ахлагчийн эзгүй байх хугацаанд нийгмийн ажилтан, түүний эзгүйд чиг үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа багийн гишүүн холбогдох маягтын дагуу хүлээн авч, бүртгэлд авна.

3.4.2. Хамтарсан багт ирсэн дуудлага, мэдээллийг шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай тохиолдолд бусад үйлчилгээнд холбон зуучилна.

3.4.3. Хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй иргэн болон хүүхдэд гэр бүлд нь чиглэсэн хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ, урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн арга хэмжээнд хамруулах зэрэг нийгмийн ажлын үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлнэ.

3.4.4. Гэр бүлийн хүчирхийлэл, нийгмийн бусад орчинд хүүхдийн эсрэг хүчирхийлэл гарахад хүргэж болох эрсдэл, тохиолдлыг эрт илрүүлэх зорилгоор олон нийт, байгууллага, иргэдийн хүчирхийллийг үл тэвчих хандлага, мэдлэгийг нэмэгдүүлэх кампанит ажлыг харъяалах нутаг дэвсгэрийн судалгаа, нөхцөл байдалд үндэслэн хэрэгжүүлнэ.

3.4.5. Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, гэр бүлийн боловсролыг эрсдэлт болон зорилтот гэр бүлд олгох, амьдралд хэвшүүлэх цуврал ажлыг зохих талуудтай эсхүл мэргэшсэн сургагч багштай хамтран зохион байгуулна.

3.4.6. Хүчирхийлэлтэй гэр бүл дэх хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх, насанд хүрэгсдийн зөрчлийг шийдвэрлэх, зэрэг гэр бүлийг дэмжих, нөхөн сэргээх сургалт, зөвлөгөө, дэмжлэгт хамруулна.

3.4.7. Сургуулийн нийгмийн ажилтан, цэцэрлэгийн арга зүйч нь Боловсролын хуульд зааснаас гадна гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийн 26.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, 6.3.4-т заасан үйлчилгээг үзүүлэх, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журмыг хэрэгжүүлж ажиллана.

3.4.8. Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, гэр бүлийн боловсролыг эрсдэлт болон зорилтот гэр бүлд олгох, амьдралд хэвшүүлэх цуврал ажлыг зохих талуудтай эсхүл мэргэшсэн сургагч багштай хамтран зохион байгуулна.

3.4.9. Сургуулийн нийгмийн ажилтан, арга зүйч хүчирхийлэлд өртсөн хүүхдэд сургууль, цэцэрлэгийн хүүхэд хамгааллын багтай хамтран хамгааллын үйлчилгээ үзүүлнэ.

3.5. Халамжийн нийгмийн ажилтан:

3.5.1. Хамтарсан багт хандсан дуудлага, мэдээллийг цагдаагийн алба хаагч болон багийн ахлагчийн эзгүй байх хугацаанд нийгмийн ажилтан, түүний эзгүйд чиг үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа багийн гишүүн холбогдох маягтын дагуу хүлээн авч, бүртгэлд авна.

3.5.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 40.1-д заасны дагуу хохирогчийг нийгмийн халамжийн холбогдох үйлчилгээнд, Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.2.22-т заасны дагуу хүчирхийлэлд өртсөн хүүхдийг асран хамгаалах, харгалзан дэмжих үйлчилгээ үзүүлж байгаа хүнд асаргааны тэтгэмж олгох үйлчилгээнд хамруулна.

3.5.3. Хохирогчийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу холбон зуучлахдаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/73 дугаар тушаалыг мөрдөж ажиллана.

3.5.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд хохирогчийг шаардлагатай тохиолдолд хамруулна.

3.5.5. Хохирогчийг Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах зэрэг нийгмийн амьдралд оролцох оролцоог дээшлүүлэх хөтөлбөрт хамруулна.

3.5.6. Хүчирхийлэл байнга үйлдэгддэг, эсхүл эрсдэлтэй гэр бүлийн гишүүдийг нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн болох эсэхийг холбогдох журмын дагуу тогтоох, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх бөгөөд зан үйл өөрчлөх сургалт, сайн дурын сургалтад хамруулах арга хэмжээг холбогдох албан хаагчтай хамтран хэрэгжүүлнэ.

3.6. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн нийгмийн ажилтан:

3.6.1. Хамтарсан багт хандсан дуудлага, мэдээллийг цагдаагийн алба хаагч болон багийн ахлагчийн эзгүй байх хугацаанд нийгмийн ажилтан, түүний эзгүйд чиг үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа багийн гишүүн холбогдох маягтын дагуу хүлээн авч, бүртгэлд авна.

3.6.2. Гэр бүлийн хүчирхийлэл, нийгмийн бусад орчинд хүүхдийн эсрэг хүчирхийлэл гарахад хүргэж болох эрсдэл, тохиолдлыг эрт илрүүлэх зорилгоор олон нийт, байгууллага, иргэдийн хүчирхийллийг үл тэвчих хандлага, мэдлэгийг нэмэгдүүлэх кампанит ажлыг харъяалах нутаг дэвсгэрийн судалгаа, нөхцөл байдалд үндэслэн хэрэгжүүлнэ.

3.6.3. Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, гэр бүлийн боловсролыг эрсдэлт болон зорилтот гэр бүлд олгох, амьдралд хэвшүүлэх цуврал ажлыг зохих талуудтай эсхүл мэргэшсэн сургагч багштай хамтран зохион байгуулна.

3.6.4. Хохирогч аюулын зэргийн болон нөхцөл байдлын үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гарсан тохиолдолд хамтарсан багийн нийгмийн ажилтантай хамтран ажиллана.

3.6.5. Хүчирхийлэлтэй гэр бүл дэх хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх, насанд хүрэгсдийн зөрчлийг шийдвэрлэх, зэрэг гэр бүлийг дэмжих, нөхөн сэргээх сургалт, зөвлөгөө, дэмжлэгт хамруулна.

3.6.6. Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдийг түүний хүсэл сонирхолд нийцүүлэн дугуйлан, клуб, секц, хотын үзвэр, аялал, хөгжлийн хөтөлбөр зэрэг нийгэмшүүлэх, амьдрах ухаанд сургах хөтөлбөрт хамруулна.

3.6.7. Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн хохирогчид орчуулагч, дохионы хэлмэрч, итгэмжлэгдсэн төлөөлөгч ажиллуулах шаардлагатай бол нийгмийн ажилтан хамтарсан багийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж, аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн байгууллагатай хамтран ажиллана.

3.6.8. Хамтарсан багийн шийдвэрээр хүчирхийллийн хохирогч хүүхэд, насанд хүрэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор тэдний хүсэлтээр итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилон ажиллуулах хүсэлтийг аймаг, дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

3.7. Цагдаагийн алба хаагч:

3.7.1. Хамтарсан багт хандсан дуудлага, мэдээллийг цагдаагийн албан хаагч болон багийн ахлагчийн эзгүй байх хугацаанд нийгмийн ажилтан хүлээн авч, холбогдох маягтын дагуу бүртгэл хөтлөн, энэ тухай цагдаагийн байгууллага хамтарсан багийн даргад мэдээлнэ.

3.7.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1, 39.2-т заасны дагуу хохирогчид эрх зүйн туслалцааг үзүүлнэ.

3.7.3. Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг тусгай хамгаалалтаар хангахдаа Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/39 дүгээр тушаалыг мөрдөж ажиллана.

3.7.4. Хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэхэд хэсгийн ахлагч, олон нийтийн цагдаа, иргэдийн дэмжлэгийг авч болно.

3.7.5. Хүчирхийллийн шинжтэй дуудлага, мэдээлэлд очсон Цагдаагийн албан хаагч шаардлагатай гэж үзвэл хохирогчоос зөвшөөрөл авахгүйгээр зураг авах, дуу дүрсний бичлэг хийх, зарим баримтыг хувилж авах зэргээр хүчирхийллийн тохиолдлыг баримтжуулна.

3.7.6. Хамтарсан багийн ахлагч болон цагдаагийн алба хаагч нь хохирогчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 33.1.1, 34 дүгээр зүйлд заасан аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэгжүүлэх, шаардлагатай хохирогчийн иргэний бүртгэлийн бичиг баримтын зөрчлийг арилгуулна.

3.7.7. Хүчирхийлэл үйлдэгчийг зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтад хамруулах арга хэмжээг Хамтарсан багийн ахлагч зохион байгуулж, Цагдаагийн албан хаагч хамтран хэрэгжүүлнэ.

3.7.8. Хүчирхийллийн хохирогчид хууль, эрх зүйн туслалцаа үзүүлж, Хүүхдийн эрхийн Хууль зүйн хороотой хамтран ажиллана.

3.7.9. Баг, хорооны нутаг дэвсгэрт гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой удаа дараа өгсөн дуудлага, мэдээллийн талаарх судалгааг сар бүр гаргаж, хамтарсан багаар хэлэлцүүлэн, хяналт тавих, хариу арга хэмжээ зохион байгуулж ажиллана.

3.7.10. Гэр бүлийн хөгжлийн газрын сэтгэл зүйч эзгүй байх хугацаанд цагдаагийн байгууллагын сэтгэл зүйч болон сургуулийн сэтгэл зүйчээр үйлчлүүлэгчийн сэтгэл санааны байдал, амиа хорлох эрсдлийн түвшинг харгалзан сэтгэл зүйн дэмжлэг үзүүлнэ.

Дөрөв. Хамтарсан багийн үйл ажиллагааг санхүүжүүлэх

4.1. Хамтарсан багийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөв, хуулиар завшөөрөгдсөн бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

4.2. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилладаг боловсрол, эрүүл мэнд, цагдаа, олон нийтийн байцаагч нь тухайн нутаг дэвсгэртээ зохион байгуулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг бичил төсөл хэрэгжүүлэх замаар аймаг, нийслэл, сум, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн санхүүжилтээр зохион байгуулна.

4.3. Хамтарсан багийн үзүүлсэн үйлчилгээний чиглэлээс хамааран санхүүжилтийг харъяалах салбарын төсвөөс санхүүжүүлнэ.

4.4. Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т заасны дагуу хэлэлцэн батална.

4.5. Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг үзүүлсэн үйлчилгээ тус бүрээр Хүүхэд хамгааллын тухай хуулинд заасны дагуу орон нутгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтсээс санхүүжүүлнэ.

4.6. Хамтарсан багийн тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг санхүүжүүлэх зардлыг аймаг, дүүргийн Засаг дарга жил бүр гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардал, хүүхэд хамгааллын зардалд тус тус тусгаж, шийдвэрлэнэ.

4.7. Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэхээр магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага, иргэнтэй хамтран ажиллаж, санхүүжүүлж болно.

Тав. Хамтарсан багийн үйл ажиллагааны тайлагналт, хяналт-шинжилгээ ба үнэлгээ

5.1. Хамтарсан багийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, мэдээллийг нарийн бичгийн дарга нийгмийн ажилтны мэдээллийн санд /НАМС/ заавал оруулна.

5.2. Тухайн аймаг, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан нутгийн захиргааны байгууллага нь хамтарсан багийн үйл ажиллагаа ба үйлчилгээ, санхүүгийн зарцуулалтад хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

5.3. Тухайн аймаг, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан нутгийн захиргааны байгууллага нь Хамтарсан багийн үйл ажиллагааны болон санхүүгийн зарцуулалтад хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний нэгдсэн тайланг аймаг, дүүргийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулна.

5.4. Гэмт хэргээс урьчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Хамтарсан багийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлантай танилцаж, дүгнэлт, зөвлөмж өгч, чиглэл хүргүүлнэ.

5.5. Үйл ажиллагааны хяналт шинжилгээ, үнэлгээ

5.5.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Нийгмийн ажилтны мэдээллийн санд оруулсан тайлан, мэдээллийг үндэслэн, тоон болон чанарын үзүүлэлтээр дүгнэнэ.

5.5.2. Хамтарсан багийн удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа ба үйлчилгээний үр дүнд баримт бичигт суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ багийн төлөвлөгөө тайлан, хурлын тэмдэглэл, үйлчлүүлэгчийн хувийн хэрэг, нарийн бичгийн даргын сар бүрийн өөрийн хяналтын хуудас зэрэгтэй танилцаж тоон үзүүлэлт, үр дүнгийн буюу чанарын үзүүлэлтийг нэгтгэн дүгнэж гаргана.

5.5.3. Хамтарсан багийн урьдчилан сэргийлэх үйлчилгээний үр дүн, үр нөлөөг ажлын төрөл, тоо, оролцогсдын тоо, хүргэсэн мэдээллийн агуулга чанар, зохион байгуулалтад оролцсон гишүүдийн болон хамтран ажилласан байгууллагын тоо, тохиолдлын тооны өсөлт, бууралтад хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж дүгнэнэ.

5.5.4. Хамтарсан багийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг үнэлэхдээ санамсаргүй түүврээр сонгогдсон үйлчлүүлэгчийн хувийн хэрэгт чанарын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж болно.

5.5.5. Үйлчлүүлэгчийн хувийн хэрэгт чанарын хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ аюулын зэргийн үнэлгээ болон нөхцөл байдлын үнэлгээний тоо, аюулгүй байдлын хамгаалалт, хохирогч болон түүний гэр бүлд үзүүлсэн эрүүл мэнд, сэтгэл зүй, хөдөлмөр, халамжийн үйлчилгээ, эрх зүйн туслалцаа, холбон

зуучилсан бусад үйлчилгээ тус бүрээс гарсан үр нөлөөнд тоон болон чанарын үнэлэлт, дүгнэлт өгөх аргаар хийнэ.

5.5.6. Шаардлагатай гэж үзвэл нарийн бичгийн дарга, бусад гишүүдтэй ганцаарчилсан ярилцлага хийх замаар Хамтарсан багийн үйл ажиллагаа, үйлчилгээний үр дүн, үр нөлөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж болно.

5.5.7. Нарийн бичгийн дарга сар бүрийн эцэст өөрийн хяналтын хуудсаар Хамтарсан багийн үйл ажиллагаа, үйлчилгээний үр дүн, үр нөлөөг хянаж, үнэлэн дүгнэлтийг багийн сарын тайланд бичиж, багийн ахлагч болон гишүүдэд танилцуулан, шаардлагатай зөвлөмж, анхааруулгыг өгнө.

5.6. Санхүүгийн хяналт шинжилгээ, үнэлгээ

5.6.1. Хамтарсан багийн санхүүжилт ба зарцуулалтын хэмжээ, түүний хүрэлцээтэй эсхүл илүүдэлтэй байдал, оновчтой зөв зарцуулалт зэрэгт санхүүжилтийн бүртгэлийн маягт, бүрдүүлсэн баримтад тулгуурлан санхүүгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмжийг гаргана.

5.6.2. Хамтарсан багийн санхүүжилтийн үр дүн, үр нөлөөнд хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ хийлгүүлж болно.

Зургаа. Санхүүгийн баримт бүрдүүлэх

6.1. Санхүүжилтийг гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, бүртгэх, шалгах, хүчирхийллийг таслан зогсоох, үйлчлүүлэгчид нөхцөл байдлын үнэлгээ хийх, үнэлгээнд үндэслэн нийгмийн хамгааллын үйлчилгээг үзүүлэх, шаардлагатай бусад нарийн мэргэжлийн үйлчилгээнд холбон зуучлах, зорилтот урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хэрэгжүүлэх болон эдгээртэй холбоотой бусад үйл ажиллагааг зохион байгуулахад зарцуулна.

6.2. Санхүүжилтийг сум/баг, хорооны хамтарсан багийн гишүүн, аймаг, нийслэл, сум, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн байгууллагын ажилтанд олгож, зардлын хүснэгтэд бүртгэж, санхүүгийн анхан шатны баримтаар баталгаажуулна.

6.3. Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар магадлан итгэмжлэгдсэн, төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллага нь зарцуулалтыг санхүүгийн анхан шатны баримт болон үйл ажиллагааны тайлангаар баталгаажуулна.

6.4. Үйлчилгээ, үйл ажиллагааны зардлыг санхүүжилтийн бүртгэлийн маягтад бүртгэж, санхүүгийн анхан шатны баримт (кассын талон, такси, шатахууны баримт, гарын үсэг)-аар баримтжуулах ба улирал бүр санхүүгийн хяналт, шалгалтад тайлагнана.

6.5. Санхүүгийн анхан шатны баримт авах боломжгүй зарим зайлшгүй нөхцөлд уг журмын хавсарлтын маягтууд болон, зураг, бичлэг зэргээр баримтжуулсан тайланг санхүүгийн баримтад хүлээн зөвшөөрч болно.

Долоо. Хариуцлага

7.1. Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ТӨСӨӨГ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны сарын....-ний өдрийн/...../..... тоот хамтарсан тушаалаар баталсан журмын нэгдүгээр хавсралт

НЭГ. ХАМТАРСАН БАГААС ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИШИГ ЗАРДЛЫГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

1.1. Урьдчилан сэргийлэх үйлчилгээ:

1.1.1. Хамтарсан багаас үзүүлэх урьдчилсан сэргийлэх үйлчилгээний зардалд сургалт, сурталчилгаа, олон нийтийг хамарсан нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулахад шаардагдах санхүүжилт орно.

1.1.2. Урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардлыг тухайн жилийн төлөвлөгөөнд үндэслэн сургалтын тоо, хамрагдсан хүний тоонд үндэслэн тооцно.

1.1.3. Олон нийтийг хамарсан нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулахдаа харьяалах орон нутгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах дэд зөвлөл, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэстэй хамтран зохион байгуулж, санхүүжилтийг холбогдох байгууллагууд шийдвэрлэнэ.

ЖИШИГ ЗАРДЛЫГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

1.1. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, сургалт, нөлөөллийн ажил хийх жишиг зардал:

1.1.1. Хамтарсан багаас үзүүлэх урьдчилсан сэргийлэх үйлчилгээний зардалд сургалт, сурталчилгаа, олон нийтийг хамарсан нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулахад шаардагдах санхүүжилт орно.

1.1.2. Сургалт, сурталчилгааны зардлыг тухайн жилийн төлөвлөгөөнд үндэслэн сургалтын тоо, хамрагдсан хүний тоонд үндэслэн тооцно.

1.1.3. Олон нийтийг хамарсан нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулахдаа харьяалах орон нутгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах дэд зөвлөл, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэстэй хамтран зохион байгуулж, санхүүжилтийг холбогдох байгууллагууд шийдвэрлэнэ.

1.1.4. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, сургалт, нөлөөллийн ажиллагаа зохион байгуулах зардлын суурийг сургалтын төрлөөс хамааруулан харгалзах зардлын индексээр харгалзуулан зардлыг тооцно.

1.1.5. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, сургалт, нөлөөллийн ажиллагааны төрөл, зайлшгүй шаардлагаас хамааран сургалтын зардлын бүрэлдхүүнд томилолтын зардал тусгаж болно.

1.2. Нөхцөл байдлын үнэлгээ:

1.2.1. Нөхцөл байдлын үнэлгээ хийх зардлыг хүүхэд хамгааллын жишиг зардлыг үндэслэн үйлчилгээ үзүүлэх зардал, нөхцөл байдлын үнэлгээ хийхэд шаардагдах бусад зардал гэж ангилна.

1.3. Нөхөн сэргээх үйлчилгээ:

1.3.1. Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.8-д зааснаас бусад эрүүл мэндийн төлбөртэй эмчилгээ, үйлчилгээний зардалд төлбөрийн чадваргүй хохирогчид дэмжлэг үзүүлнэ.

1.3.2. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах нөхцөл, журмыг хангасан үйлчлүүлэгчийг Нийгмийн халамжийн тухай хуулинд заасны дагуу үйлчилгээ үзүүлж, санхүүжүүлнэ.

1.3.3. Амьжиргааны түвшин доогуур гэр бүлийн хохирогч нарт нэг удаагийн хоол хүнс, хувцас, ариун цэврийн хэрэгслийн туслалцааг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/150 дугаар тушаалаар батлагдсан “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардлын дундаж норматив”-ын жишгээр тооцно.

1.3.4. Үйлчлүүлэгч сэтгэл зүйн оношилгоо тогтоох, ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, гэр бүлийн сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг нарийн мэргэжлийн Сэтгэл зүйчээс авч болох ба үйлчилгээний төлбөрийг үзүүлсэн үйлчилгээний баримтад үндэслэн олгож, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Ерөнхий захирлын “Төлбөртэй тусламж, үйлчилгээ үзүүлэх тухай” 2019 оны А/73 тоот тушаалын хоёрдугаар хавсралтын “Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт, үнийн тариф” дагуу олгоно.

1.3.5. Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх журмын дагуу үйлчлүүлэгчид сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээний төлөвлөгөө гаргах ба үйлчлүүлэгчийн нөхцөл байдал, үйлчилгээний үр дүнгээс хамаарч давтамжийг тооцно.

1.3.6 Эрх зүйн туслалцааны зардлыг Зардлын жишгийг тооцохдоо Хүүхэд хамгааллын үйлчилгээний норматив, санхүүжүүлэх аргачлалыг тооцохоос гадна нарийн мэргэжлийн хуулийн туслалцаа шаардлагатай тохиолдолд шаардагдах зардлыг хуулийн байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, хүүхэд хамгааллын зардлаас санхүүжүүлнэ.

1.3.7. Холбон зуучлах үйлчилгээний зардалд тээврийн хөлс, харилцаа холбооны зардал болон Иргэний бүртгэлийн байгууллагатай холбогдох зардлыг оролцуулж тооцно.

1.3.8. Нөхөн сэргээх болон холбон зуучлах үйлчилгээний үйлчилгээ үзүүлэх албан хаагчдын хөлсийг 1 иргэнтэй ажилласан цагийг үндэслэн тооцож олгоно.

1.3.9. Хамтарсан багийн үйлчилгээний жишиг зардалыг тооцохдоо нөхцөл байдлын үнэлгээ хийх болон нөхөн сэргээх холбон зуучлах үйлчилгээний зардлыг дундажлаж, Хамтарсан багийн гишүүд болон үйлчилгээ үзүүлэх ажилчдын нэг цагийн хөлсийг ажилласан цагт үндэслэн тооцно.

ХАМТАРСАН БАГААС ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИШИГ ЗАРДАЛ:

Урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардал								
№	Зардлын утга	Зардлын суурь	Олон нийтийн сургалт, нөлөөллийн ажил		Гэр бүлд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажил		Боловсон хүчин чадавхижуулах	
			Индекс	Өртөг	Индекс	Өртөг	Индекс	Өртөг
1.	Сургагч багшийн зардал	40,000	0.009	360	0.009	360	0.25	10,000
2.	Цайны зардал	2,500	0	0	0	0	1	2,500
3.	Сургалтын хэрэглэгдэхүүний зардал	3,000	0.006	18	0.006	18	1	3,000
4.	Томилолтын зардал	69,000		0		0	10	690,000
	Нийт зардал	114,500		378		378		705,500

Тайлбар: Сургагч багшийн зардал: Орон нутаг, нийслэлийн хүүхэд хамгааллын чиглэлийн 324 ажилтнуудын хамрагдсан судалгаанд үндэслэн голчлон хамрагддаг сургалт, тэдгээрийн сургагч багшийн дундаж хөлсөөр тооцсон.
Сургалт зохион байгуулах зардлыг тооцохдоо Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А58 дугаар тушаалаар батлагдсан “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэний тоо, шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлох аргачлал”-ын жишиг болгоно.
Томилолтын зардал: Сангийн сайдын 2018 оны 12 сарын 27-ны 301 дүгээр тушаалаар баталсан тарифаар тооцов.

Нөхцөл байдлын үнэлгээ хийх зардал			
№	Зардлын төрөл	Тооцох нэгж	Зардлын хэмжээ /төгрөг/
1.	Бичиг хэргийн зардал	1 удаа	5,000
2.	Холбон зуучлах зардал	1 удаа	2,000
3.	Баримтжуулах зардал	1 удаа	2,500
4.	Томилолтын зардал	1 удаа	30,833
	Нийслэлд	1 удаа	12,000
	Аймгийн төвд	1 удаа	50,000
	Сумдад	1 удаа	30,500
	Нийт/нийслэл/		21,500
	Нийт/аймаг/		50,000
	Нийт/сум/		30,500
	Дундаж зардал		40,333

Тайлбар: Зардлын жишгийг тооцохдоо Хүүхэд хамгааллын үйлчилгээний норматив, санхүүжүүлэх аргачлалыг үндэслэнэ. Бичиг хэргийн зардал, холбон зуучлах зардал, баримтжуулах зардлыг анхан шаардагдах материалыг зах зээлийн үнэд тулгуурлан гаргасан. Жишээ нь бичиг хэргийн зардалд НБҮнэлгээ, эрсдлийн зэргийн үнэлгээ хийх маягт болон хувийн хэрэг нээхэд шаардлагатай бичиг хэргийн зардал, холбон зуучлах зардалд харилцаа холбооны зардал, баримтжуулах зардалд CD, DVD-д бичлэг буулгах, зургаар баримтжуулж угаалгах зэрэг зардлыг дунджаар тооцож оруулсан. Томилолтын зардлыг Сангийн сайдын 2018 оны 12 сарын 27-ны 301 дүгээр тушаалаар баталсан тарифыг урвуу байдлаар жишиг болгон тооцсон.

Д/д	Зардлын төрөл	Тооцох нэгж	Зардлын хэмжээ /төгрөг/
Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх			

1.	Сэтгэл зүйн оношлогоо	1 удаа	5,000
2.	Сэтгэл заслын үйлчилгээний хэрэглэгдэхүүн /тоглоом, зургийн хэрэгсэл, бичиг хэрэг/	1 удаа	10,000
3.	Сэтгэл зүйн зөвлөгөө	1 удаа	25,000
		Дундаж	40,000
Тайлбар: Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Ерөнхий захирлын “Төлбөртэй тусламж, үйлчилгээ үзүүлэх тухай” 2019 оны А/73 тоот тушаал			
Эрх зүйн туслалцаа үзүүлэх			
1.	Эрх зүйн зөвлөгөө	1 удаа	8,000
		Дундаж	8,000
Тайлбар: Одоо ашиглагдаж буй хуульчийн дундаж цалингийн жишиг /Монголын хуульчдын холбоо/			
Иргэнийг бичиг баримтжуулах			
1.	Төрсний гэрчилгээ ¹	1 удаа	10,000
2.	Иргэний үнэмлэх	1 удаа	30,000
3.	Иргэний үнэмлэх яаралтай	1 удаа	26,600
4.	Архивын болон иргэний бүртгэлийн лавлагаа	1 удаа	1,000
5.	Архивын дэлгэрэнгүй лавлагаа	1 удаа	5,000
6.	Нотариатын үйлчилгээ	1 удаа	10,000
		Дундаж	56,100
Тайлбар: МУЗГ-ын 2020 оны 230 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээ”			
Холбон зуучлах үйлчилгээний зардал			
1.	Нийслэлд	1 удаа	12,000
2.	Аймгийн төвд	1 удаа	50,000
3.	Суманд	1 удаа	30,500
	Тээврийн зардал /дундаж/	1 удаа	40,333
4.	Бичиг хэрэг	1 удаа	5,000
5.	Иргэнийг бичиг баримтжуулах	1 удаа	10,000
		Дундаж зардал	29,000
Нөхөн сэргээх үйлчилгээний үзүүлэх зардал <i>/1 цагт ногдох хөдөлмөрийн хөлс/</i>			
1.	Кэйс менежер	1 цагт ногдох	3,793
2.	Хамтарсан багийн гишүүд	1 цагт ногдох	2,500
3.	Сэтгэл зүйн үйлчилгээ	1 цагт ногдох	15,000
4.	Хууль зүйн үйлчилгээ	1 цагт ногдох	8,844
5.	Эрүүл мэндийн үйлчилгээ	1 цагт ногдох	4,312
		Дундаж зардал	34,449
Хамтарсан багын гишүүдийн урамшуулал, үйлчилгээний дундаж зардал			
1.	Урамшуулал²	1 цагт ногдох	3,793
		Дундаж зардал	643,238
1.1	Бэлгийн хүчирхийлэл	1 хүүхэдтэй ажиллах дундаж цаг /46 цаг/	174,463
1.2.	Бие махбодын хүчирхийлэл	1 хүүхэдтэй ажиллах дундаж цаг /14 цаг/	53,097
1.3.	Сэтгэл санааны хүчирхийлэл	1 хүүхэдтэй ажиллах дундаж цаг /14 цаг/	53,097
		Дундаж зардал	93,552 /1.1-1.3/

² 1 цагт ногдох хөлсийг ажилласан цагаар тооцож олгоно.

**САНХҮҮГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ХИЙХ
ҮНЭЛГЭЭНИЙ ХҮСНЭГТ**

Санхүүжилтийн хугацаа: _____ Санхүүжилтийн хэмжээ: _____ Огноо: _____

Д/д	Үйлчилгээний нэр	Нийт тоо	Оролцогс-дын нийт тоо	Гарсан нийт үр дүнгийн тоо	Санхүүжилтийн нийт хэмжээ (мянган төгрөг)	Оноо (1-5 оноогоор дүгнэнэ)
1	Удирдлага, зохион байгуулалтын зардал					
2	Хамтарсан багийн кейс шийдвэрлэсэн хуралдааны тоо					
3	Урьдчилан сэргийлэх ажиллагаа үйл					
4	Хохирогчид үзүүлсэн үйлчилгээ					
5	Гэр бүлд үзүүлсэн үйлчилгээ					
	Нийт дүн					

Дүгнэлт:

1. Санхүүжилтийн хэмжээ хүрэлцээтэй байсан эсэх:

2. Санхүүжилтийн зарцуулалт оновчтой байсан эсэх:

3. Санхүүжилтийг нэмэгдүүлэх шаардлагатай эсэх:

4. Санхүүжилтийг хасах шаардлагатай эсэх:

5. _____
6. Санхүүжилт, зарцуулалтад өгөх зөвлөгөө, чиглэл:

**Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн мэргэжилтний
Овог нэр, гарын үсэг:** _____

**Танилцсан хүний албан тушаал,
Овог нэр, гарын үсэг:** _____

НУУЦЫН ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Энэхүү гэрээг Хувь хүний нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3, 5.4, 6 дугаар зүйл, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 7 дугаар зүйлийн 7.2, 8 дугаар зүйлийн 8.1.2, 23 дугаар зүйлийн 23.6, 35 дугаар зүйлийн 35.5, 42 дугаар зүйлийн 42.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтад заасан хувь хүний болон хүүхдийн нэр төр, мэдээлэл, гэр бүлийн амьдрал, эрүүл мэнд, хувийн харилцааны нууц, орон байрны халдашгүй байдал, хувийн орон зайгаа хамгаалуулах эрхийг хүндэтгэх үүднээс Нэг талаас: дүүргийн -р хороо/сум/багийн хамтарсан багийн хуралдаанд оролцож буй /цаашид А тал гэх/

..... /РД/ -тай тал, нөгөө талаас: дүүргийн
.....-р хороо/сум/багийн хамтарсан багийн ахлагч, Засаг дарга
..... нар /цаашид Б тал гэх/ харилцан тохиролцож
байгуулав.

1.2. Гэрээ нь хамтарсан багаар үйлчилгээ үзүүлж буй иргэний эрхийг хүндэтгэн Монгол улсын хууль тогтоомжид заасны дагуу хувь хүний нууцыг чандлан хадгалах зорилготой.

Хоёр. А талын хүлээх эрх, үүрэг

2.1. Хамтарсан багийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, хувь хүний талаарх мэдээллийг гадагш задруулахгүй байх үүргийг хүлээнэ.

2.2. Үйлчлүүлэгчийн амь нас, эрүүл мэндэд аюултай нөхцөл үүссэн эсхүл зайлшгүй мэдээлэх шаардлагатай гэж үзсэн мэдээллийг хамтарсан багийн гишүүдэд шуурхай өгнө.

2.3. Мэдээллийн үнэн зөв эсэхийг бүрэн хариуцна.

2.4. Хамтарсан багийн хуралдаанд зөвхөн өөрт хамаатай асуудал хэлэлцэх үед оролцох ба бусад асуудал хэлэлцэх үед оролцохгүй болно.

2.5 Хамтарсан багийн хуралдаанд оролцохдоо үйл ажиллагааг баримтжуулан авч үлдэх, бичлэг хийх, зураг авах, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (хэвлэл мэдээлэл болон facebook, twitter гэх мэт цахим мэдээллийн хэрэгсэл)-ээр мэдээлэхгүй байх үүрэг хүлээнэ.

Гурав. Б талын эрх үүрэг

3.1 Үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах, мэдээлэл авах, дэмжлэг үзүүлэх зорилгоор А талыг хамтарсан багийн хуралдаанд оролцуулна.

3.2 Үйлчилгээний явцад үйлчлүүлэгчийн нууцлахыг хүссэн зүйл нь өөрт нь эсхүл бусад хүмүүсийн эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх өндөр эрсдэлтэй байгаа, хамтарсан багийн гишүүд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд саад учруулж болзошгүй тохиолдолд Б тал үйлчлүүлэгчийн нууцийг хадгалж, хамгаалах боломжгүй тухай А талд урьдчилан мэдэгдэнэ.

3.3. А талд хуралдааны ерөнхий зарчмыг танилцуулан, эрх, үүрэг, оролцоог нь тайлбарлаж өгсөн байна.

3.4. Хамтарсан багийн өөр бусад асуудлыг хэлэлцэх үед А талыг оролцуулахгүй болно.

3.5. Б тал нь А талын нууцлалыг хамгаалж, хадгалах үүрэгтэй.

Дөрөв. Гэрээний хариуцлага

4.1 Энэхүү гэрээ нь хоёр талын гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2 Гэрээнд заасан зүйлийг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Б талыг төлөөлөн:

.....
дүүргийн хороо/сум/багийн
хамтарсан багийн ахлагч:
нэр:
.....
Гарын үсэг

А талыг төлөөлөн:

.....
дүүргийн.....
хороо/сум/ багийн хамтарсан багийн
хуралд оролцсон:
нэр:.....
Гарын үсэг

.....
Огноо:
.....

.....
РД:
Хаяг:
.....

.....
Утас:
.....

ТӨСӨӨЛ
---oOo---